



Цагаан Лянхуа Цэцгийн Судар

Эрдэнийн Суврага Үзүүлсэн нь хэмээх 11-р бүлэг

Номын багш хэмээх 10-р бүлэгт Шагжамуни будда Цагаан Лянхуа судрын сургаалыг айлдах хүн ямар сэтгэлийн бэлтгэлтэй байх, уг сургаалыг айлдсанаар ямар буян хураах талаар айлддаг.

Ингэж айлдаж дуусмагц өндөр, өргөнийг нь хэмжихийн аргагүй агуу том суврага газраас гэнэт хөөрөн гарч ирж, агаарт тогтов. Тэгтэл суврага дотроос хэн нэгний дуу маш тод сонсогдов. “Гайхамшигтай! Шагжамуни будда хамаг амьтны бурханлаг чанарыг нэвт харж, бусдын төлөө сайн үйл хийвээс будда болж чадна гэсэн Цагаан Лянхуа сударын сургаалыг айлдав. Шагжамуни буддагийн айлдсан сургаал бол жинхэнэ үнэн юм” гэсэн дуу гарав. Ингэж хэлсэн бурхан бол өмнө нь бодисадва байхдаа “Би будда болж нирваанд орохоороо Цагаан Лянхуа судар айлдах газарт агуу том суврага бий болгож, уг сургаал үнэн болохыг гэрчилэх болно” хэмээн тангаргалсан Олон Эрдэнийн Татагата байв.

Эндэнийн суврага доторх Олон Эрдэнийн Татагатагийн дууг сонссон хүмүүс баярлан, суврага дотор хэн байгаа юм бол гэж бодов. Түүнийг мэдэрсэн Амгалан айлдагч бодисадва тэр хүмүүсийг төлөөлөн Шагжамуни буддагаас суврага дотор хэн байгааг асуутал, “суврага дотор Татагата байгаа” гэж хэлэв. Амгалан айлдагч бодисадва тэр бурахныг харахыг хүсэж байгаагаа хэлтэл бурхан багш түр хүлээ гэв.

“Олон Эрдэнийн Татагатад маш гүн хүсэл бий. Тэр бол “ертөнцийн бүх будда нар цуглаж, жинхэнэ үнэн бол өөрчлөгдөшгүй бөгөөд дэлхийд зөв сургаал айлдах хүн бүхэн буддагийн хувилгаан дүр болохыг бүх хүмүүс ойлгосон цагт би өөрийн биеэ үзүүлж, уг сургаал үнэн болохыг гэрчилнэ гэсэн хүсэл билээ” хэмээн тайлбарлав.

Агуу Амгалан айлдагч бодисадва буддагийн хувилгаадыг би тахихыг хүснэ хэмээн айлтгав. Тэгтэл Шагжамуни буддагийн духнаас гэрэл цацарч 10 зүгийн ертөнцөц жинхэнэ үнэний сургаал айлдаж буй хувилгаадыг харуулсан бөгөөд хувилгаад “Шанбалын ертөнц рүү очиж, Шагжамуни буддагийн сургаал үнэн болохыг гэрчлэх цуглаанд оролцье” хэмээн ярилцаж буй нь сонсогдов. Яг тэр агшинд Шанбалын ертөнц хараад ханашгүй ариун үзэсгэлэнтэй болон хувирав.

10-н зүгийн хувилгаад нар Шанбалын ертөнцөд цугларч, Эрдэнийн суврага нээгдэхийг хүлээн сууна. Шагжамуни будда суврагын хаалгыг нээтэл Олон Эрдэнийн Татагата сууж байх нь харагдав. Олон Эрдэнийн Татагата суудалдаа зай гаргаж Шагжамуни буддаг “Энэ суудалд сууна уу” хэмээн залахад Шагжамуни будда зэрэгцэн суув.

Энэхүү үйд явдлыг харсан хүмүүс “Хувилгаан хүчээр биднийг ч бас тэнгэр лүү гаргаж өгөөсэй” хэмээн дотроо бодов. Үүнийг нь мэдсэн Шагжамуни будда тэднийг тэнгэр өөд татан гаргав. Шагжамуни будда “Би удахгүй энэ ертөнцийг халин одох тул та нарт сургаал түгээх үйлийг даалгахыг хүснэ. Шамбалын ертөнцөд энэхүү Цагаан Лянхуа сударыг түгээх хүн байна уу” гэв. Мөн ирээдүй цагт Цагаан Лянхуа Судар айлдахын хэцүүг янз бүрийн жишээгээр тайлбарлав.

Ийнхүү хамаг амьтан бүгд тэнгэрт хөөрөн гарснаар судрын үйл явдал агаарт өрнөж эхэлдэг.



Инээмсэглэлийн үр дүн

Хэн нэгэнтэй ярилцах үед тэр хүн нь сэтгэлээ түгжсэн байх юм бол хичнээн яриа өрнүүлэхийг хичээгээд ч ярисан зүйл тэр хүнд хүрэхгүй. Нэгэн хүн үүнийг хөмөрсөн аягатай төсөөлүүлсэн байна.

Хөмөрсөн аяганд юу ч хийх аргагүйтэй адил эхлээд тухайн хүнийхээ сэтгэлийн аягыг дээш харуулах хэрэгтэй. Чөлөөтэй ярилцаж, сэтгэлийг нээхэд инээд болон алиа хошин яриа том үүргийг гүйцэтгэдэг гэнэ.

Тийм болохоор ч тэр үү, олон алдартай номлогч болон яруу найрагч нар эртнээс албан ёсны яриа хийхдээ хөгжилтэй хошигнол оруулж сэтгэлийнх нь аягыг дээш харуулсныхаа дараа чухал гол зүйлээ дамжуулдаг байсан байна.

Эдогийн үеийн уран зохиолч Жиппэнша Иккү (1765–1831) “Олон юм нуршаад яах вэ. Би зүгээр л хүжний утаатай хамт энэ ертөнцөөс явлаа, баяртай” хэмээх хошигнол бичсэн байдаг. Мөн Зэн буддизмын их номлогч Иккюү Соожүн (1394–1481) “Төрсөн бүхэн үхнэ. Шагжамүни будда ч, Дарүма (Зэн буддизмыг үндэслэгч энэтхэг лам) ч, муур ч, шанага ч адилхан.” хэмээх хошигнолоор дамжуулан төрөх, өтлөх, өвдөх, үхэх гэсэн амьдралын жинхэнэ үнэнийг айлдсан байдаг.

Алиа хошин яриа нь хатуу, ширүүн хүний сэтгэлийг нээж, хүмүүс хоорондын харилцаанд эв нэгдлийг бий болгохоос гадна хүлээж авахад бэрх бодит байдалтай нүүр тулж даван туулж чадах уян хатан чанарыг өгдөг ажээ.

Бодит жишээ дурьдвал Нацистуудын



албадан хорих лаагерт хоригдон амьд үлдэж чадсан Dr. Виктор Франкл (Viktor Frankl, 1905–77) гуай хамт хоригдож байсан нөхөртөө “өдөрт нэг удаа инээж байя” гэсэн санал тавьж, харилцан инээмсэглэдэг байсан гэдэг. Энэ нь амьд үлдэх эх үндэс болсон болов уу.

Хүнд хэцүү зүйлтэй тулгарсан үед хошин наргиа зан, инээмсэглэл нь авралын гэрэл болдог. Ингэснээр сэтгэл тайвширан уужирч аз жаргалын үр соёолдог билээ.

Инээмсэглэл бол энэрэнгүй сэтгэл

Гэвч өөрөөсөө эхэлж шог хошин юм ярьж, инээх дургүй хүн ч байдаг болов уу.

Үнэндээ би ч гэсэн адилхан. Өглөө баргар царайтай гэрээсээ гарах гэтэл “Гадагшаа гарахынхаа өмнө толинд нэг өөрийгөө хараад инээж үзвэл яасан юм бэ” гэж эхнэр маань зөвлөж байсан удаа бий. Үүнийг тогтмол хийж занших юм бол инээх дургүй сэтгэл бага багаар алга болж, танилын хүрээ ч нэмэгдэнэ.

Өнгөрсөн жил эмэгтэйчүүдийн дэлхийн хөл бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээний шийдвэрлэх тоглолт эхлэх агшинд Японы тамирчид инээмсэглэл дүүрэн талбай дээр тойрон зөвлөлдөж байсан нь миний сэтгэлд тод үлдсэн билээ. Инээснээр биеэ барихгүй болж, булчин уян хатан болсноор өөрт байгаа хүч чадлаа бүрэн гаргаж чаддаг байна. Уян хатан чанар ба хүч чадлыг үзүүлж чадсан “Надэшко Жапан”-аас (2011 оны Эмэгтэйчүүдийн Дэлхийн Хөл Бөмбөгийн Аврага) үлгэр дуурайл авч өдөр бүр инээмсэглэцгээе.

Эхэндээ сэтгэлээсээ инээж чадахгүй байж

магадгүй ч инээхийг хичээгээд үзээрэй. Ингэснээр инээд нь аяндаа өөрийн жинхэнэ байгалийн инээмсэглэл болж хувирна. Яагаад гэвэл бие сэтгэл нэг байдаг тул бие гэгээлэг саруул байх тусам сэтгэл ч дагаад гэгээлэг болох учиртай.

Инээмсэглэл бол “Таньтай нөхөрлөмөөр байна” гэсэн мессэж бөгөөд хүмүүсийн хооронд эв найрамдал, халуун дулаан харилцааг бий болгодог гэж хэлж болно.

Дээр нь инээмсэглэл бол мөнгөгүй хүн ч хийж чадах өглөг буюу энэрэнгүй үйл болно. Үүнийг “Инээмсэглэлийн өглөг” гэдэг.

Хавар цаг ирж, байгаль дэлхий хүртэл баярлан өнгө зүсээ засаж байна. Бид ч гэсэн өнгө зүсээ засаж, уян зөөлөн, уужим бөгөөд эелдэг энэрэнгүй сэтгэлийн эх булаг болох инээмсэглэлийг марталгүй, өөдрөг гэгээлгээр бурханы үйлийг хэрэгжүүлцгээе.

“Косэй” 2012 оны 5 сарын дугаараас



Инээмсэглэл бол тэнгэрийн цэцэг

Рисшо Косей Кай нийгэмлэгийн
ирээдүйн тэргүүн
Нивано Коошо

Шатаар буутал...

Гурав дахь охин маань цэцэрлэгт ороод удаагүй байхад яагаад ч билээ нэгэн ялихгүй зүйл дээр охиноо загнаж байсан юм.

-Яасан ч дахин ингэж болохгүй шүү, ойлгосон уу?

-Ойлгосон.

Ингэж хэлээд уйлангаа шатаар буух жоохон охиндоо хатуу үг хэлчихсэндээ миний сэтгэл их хүнд оргив. Ингэж хэлэхгүй байсан ч болох л байсан. Охиноо загнаж байхдаа үнэндээ өөрийнхөө бухимдлыг гаргаж байгаа юм биш биз гэж бодсон боловч өөрийгөө барьж чадаагүй юм.

Охиноо гайгүй байгаа гэж бодоод араас нь шатаар буутал охин эмээгийнхээ өрөөнд орсон бололтой байв. Уг нь эмээгийнхээ өрөөнд нэг их ордоггүй мөртлөө надад загнуулаад эмээгийнхээ өрөөг яаралтай хоргодох байр болгосон болтой байв. Удалгүй ээж өрөөнөөсөө гарч ирээд ингэж хэлэв.

-Өө, чи энд байсан юм уу. Энэ хүүхдэд өнөөдөр ямар нэг сайхан зүйл тохиолдоо юу?

-Юу? (гайхав)

-Амандаа дуу аялангаа хаалга тогшоод “эмээ, гоё амттай юм байна уу?” гээд сэргэлэн цовоо өрөөнд орж ирсэн ш дээ.

Шатаар буухдаа яах аргагүй уйлж байсан болохоор, эмээ дээрээ очоод тайтгаруулуулж байгаа биз гэж би бодож байв. Тэгтэл сэргэлэн цовоо амттай юм авч идээд байж байх гэж... Шатаар буух зуураа сэтгэлээ сэргээчихсэн юм болов уу?

Дэндүү хурдан сэтгэлээ өөрчилсөнд нь гайхаж, загнуулсан гэдгээ ч ойлгоогүй юм болов уу гэж бодов. Мөн охиндоо хэт ширүүн үг хэлээд гомдоочихов уу даа гэж зовж байсан миний сэтгэл уужирав. Тэгээд загнуулсан ч дахин босож чадах уян хатан сэтгэл охины минь дотор боловсорч байгааг би хараад баяртай байсан.

Бодоод үзвэл хүүхдүүд маань эцэг, эх биднээс гадна өвөө, эмээ, авга, нагац гээд олон хүмүүстэй хамт амтдардаг. Мэдээж хэрэг ээж болох



Рисшо Косей Кай нийгэмлэгийн ерөнхийлөгч Нивано Ничикогийн том охин бөгөөд Токио хотод мэндэлсэн.

Хуулч мэргэжлээр их сургуулиа төгссөний дараагаар тус нийгэмлэгийн удирдах албаны мэргэжилтэн бэлтгэх “Гакүрин” сургуулийн үндсэн ангид элсэн суралцаж төгссөн.

Өдгөө Цагаан Лянхуа Сударыг судлангаа нийгэмлэгийн гишүүд болон сүсэгтэн олонд ном айлдаж, гадна дотны шашны байгууллагатай хамтран ажиллах тал дээр анхааран ажиллаж байна. Түүнчлэн тус нийгэмлэгийн дараагийн ерөнхийлөгчөөр сонгогдоод байгаа.

Тэрээр нөхөр Мүнэхиро болон нэг хүү, гурван охины хамт амьдардаг.

миний хүсэл хамгийн түрүүнд тавигдах албагүй бөгөөд гэр бүлийн тогтсон хүмүүжүүлэх арга зэрэг зүйл ч байхгүй. Ядаж эхийнхээ үгийг жоохон ч гэсэн сонсох болов уу гэж бодсон ч, бодит байдал дээр хүүхдүүд маань өөр өөр үзэл бодолтой олон хүмүүс дунд өсөж том болох нь ойлгомжтой.

Энэ байдлыг өнөөг хүртэл “хэцүү боловч хүлээж авахаас өөр аргагүй” гэж би боддог байлаа.

Гэвч тэр үед би гэнэт ингэж бодсон юм. “Аан. хүүхэд том болоод нийгэмд гарах үед нийгэмд тогтсон хэв маяг, ертөнцийг үзэх үзэл гэж байдаггүй. Хүүхэд одооноос янз бүрийн үзэл бодолтой тулгарч, зарим хүнд нь тааруулж, зарим хүнийг нь эсэргүүцэж, ганцаардлыг мэдэрч, эсвэл ойлгож өгөх хүнтэй таарах явцдаа тэр дундаас өөрийн зөв гэж бодсон зүйлээ өөрөө сонгож амьдрах юм байна. Нийгмийн өөр өөр үзэл бодолтой хүмүүс дотор өөрийнхөө үзэл бодлыг гээлгүй, алдаа гаргахаас айлгүйгээр эргэн тойронтойгоо нийцэж сайхан амьдралыг туулна. Түүний тулд гэр бүлийн хүмүүжил маш чухал бөгөөд гэр бүлд тогтсон үзэл баримтлал байхгай байсан нь дээр юм байна”.

Ингээд бодоод үзвэл манай гэр бүл зөв сайхан гэр бүл байв.

Ингэж бодож дуусаад анзаартал охин маань шатны доороос намайг хараад зогсож байв.

-Ээж ээ, саяны болсон явдалд уучлаарай.

-Үгүй ээ, харин ч ууртай ээж болсонд уучлаарай. Одоо ингээд сайндах уу?

-Тэгье.

-Чихэр амттай байсан уу?

Гэр бүл хэмээх жижигхэн нийгмийн үйл явдал жоохон охинд минь маш их хүч чадал өгдөг юм байна гэдгийг би ойлгосон юм.

Хамаг амьтныг үзэн баясагч бодисадва болохын төлөө

Бразил нийгэмлэг
ФЕРНАНДО ЭНХИК

Бразил нийгэмлэгийн Хамтран үндэслэгчийн амин өдрийн номын хурал дээр тавигдсан илтгэл (2011.09.10)



Та бүгдэд энэ өдрийн мэндийг хүргэе. Намайг Фернандо Энхик гэдэг. Рисшо Косей Кай нийгэмлэгийн Бразил дахь салбарын үйл ажиллагаанд оролцож эхэлснээс хойш ойролцоогоор жил хагас болж байна. Нийгэмлэгийн ойролцоо дугуйтай явж байгаад Бразил дахь сүмд буддизмын семинар болж байгааг зарлалын самбар дээрээс олж харан оролцсоноос хойш тогтмол сургаал суралцах болж, одоо аз жаргалтай аж төрж байна.

Энэ оны 4-р сарын сүүлээр нийгэмлэгийн ойролцоох Шякара Крабин нэртэй метроны буудалд явж байхдаа төмөр зам руу унаж осолдсон юм. Бурханы авралаар амьд гарсан ч нэлээд хэдэн газраа гэмтэл авсан. Ялангуяа хавирга болон баруун гарандаа авсан шарх их хүнд байв. Эрчимт эмчилгээний тасагт олон хоног хэвтэж эмчлүүлсэн бөгөөд хариуцагч эмч баруун гарандаа хагалгаа хийлгэх шаардлагатай гэж хэлэв.

Эмчилгээ хийлгэхэд удаан хугацаа шаардлагатай гэдгийг сонсоод би цочролд орсон. Толгойд хамгийн түрүүнд орж ирсэн бодол бол Бразилийн сүм байгуулагдсаны 40 жилийн ойн арга хэмжээний судрын уншлага дээр бөмбөрний үүрэг хүлээн авсан байснаа санаж, бөмбөр цохиж чадахгүй бол яана гэхээс сэтгэл зовинож байв. Түүчлэн ажлаа

хийх, дугуйгаар явах, савхаар хооллох, жолоо барих, Япон хэл үзэх зэрэг өдөр тутам хийдэг зүйлсээ ч хийж чадахгүй болно гэдгийг ойлгов. Эцсийн дүнд эмчилгээний төлөө эдгээрээс татгалзаж, урт хугацааны турш хаашаа ч хөдөлж чадахгүй болов.

Сэргээх эмчилгээ хийлгэж байхдаа би нийгэмлэг дээр заалгасан зүйлийг санах. Энэ бол “надад тохиолдсон энэ үйл явдлаас би юуг сурч, юуг ойлгох хэрэгтэй вэ?” гэсэн зүйл байв.

Мэдээж би энэ үйл явдлаас олон зүйлийг сурсан юм. Гэхдээ тэр дундаас нэгэн үйл явдал сэтгэлд хоногшиж үлдсэн билээ.

Бага багаар алхдаг болмогц нийгэмлэг дээр зохион байгуулагдаж буй дунд түвшиний буддизмын семинарт оролцов. Тэр үед нийгэмлэгийн тэргүүн “Нийгэмлэг бол ямар нэг гайхамшигтай зүйл тохиолдохыг хүсдэг газар биш. Мөн судар уншиж хурдан асуудлаа шийдэх гэдэг газар ч биш. Яг одоо хэмээх энэ цаг мөчид талархаж, судар номоо хурцгаая” гэж хэлсэн юм. Үүгийг сонсоод миний сэтгэл маш их хөдлөв.

Өнгөрсөн 8 сард баруун гартаа хагалгаа хийлгэхийн өмнөх өдөр би чин сэтгэлээсээ одоогийн байдалдаа талархсан юм. Бурханаас би юу ч гуйгаагүй ба аз жаргал дүүрэн гэртээ харьж ирэв. Дараах өдөр нь Санта Круз эмнэлэг уруу явахдаа Үүсгэн байгуулагчийн бичсэн “Цагаан Лянхуа Судрын орчин цагийн тайлбар” хэмээх номны Португал хэл дээрх хувилбарыг авч явав. Эмнэлэгийн хүлээн авах тасгаас надад 407-р өрөөг гаргаж өгөв. Яагаад ч юум 407 хэмээх энэ тоо надад ямар нэг утгыг илэрхийлж буй мэт санагдав.

Уншихаар авчирсан “Цагаан Лянхуа Судрын орчин цагийн тайлбар”-ыг гарган 407 хуудсыг нээж үзэв. Тэнд дараах мөрийг бичсэн

**Хагалгааны өмнөх өдөр би
чин сэтгэлээсээ одоо байгаа
байдалдаа талархсан юм.
Бурханаас би юу ч гуйгаагүй.
Аз жаргал дүүрэн гэр лүүгээ
харьсан билээ.**

байв.

“Гэтэл тэнд цугласан Бодисадва нар болон олон тэнгэрүүд, хүмүүн болон хүмүүн бус янз бүрийн амьтад Хамаг амьтныг үзэн баясагч бодисадвагийн гар шатааж үгүй болсныг хараад гаслан гашиуудав. Хамаг амьтныг үзэн баясагч бодисадва бол биднийг сургаалын замд хөтөлсөн ачит багш билээ. Гэсэн атал одоо хоёр гараа шатааж бараад дутуу биетэй болж орхилоо. Одоо яах билээ хэмээн харамсан уйлалдав. Үүнийг харсан Хамаг амьтныг үзэн баясагч бодисадва бээр тэдгээр нүүгүүдийг тайвшруулан, ийнхүү тангараг өргөв.

“Та бүхэн сонсохтун. Би бээр хоёр гараараа өргөл барин шатаасан боловч, оронд нь алтан өнгөтэй бурханы биеийг олсон хэмээн итгэж байна. Өөрөөр хэлбэл бурханы сургаалыг өөрийн биеэрээ хэрэгжүүлсэн тул бурханы билиг оюуныг олсон хэмээн бодож байна. Хэрэв миний хэлсэн үгэнд худал үгүй болвоос хоёр гар минь эргэн хэвэндээ орох буй за.” хэмээв.

Хамаг амьтныг үзэн баясагч бодисадва ингэж хэлж дуусмагц шатсан хоёр гар нь урган гарч, эргэн хэвэндээ орж орхив. Учир нь энэхүү Хамаг амьтныг үзэн баясагч хэмээх бодисадвагийн үйл болон хураасан буян, билиг оюун нь маш гүн гүнзгий байсан бөлгөө. Хамаг амьтныг үзэн баясагч бодисадвагийн хоёр гар эргэн ургахыг тэнгэр газрын хамаг амьтад хамтаар үзэн баясаж, урьд хожид байгаагүйгээр баярлан хөөрөв.

Өөрөө шатаасан гар нь эргэн ургасан гэдэг нь бодисадва нарын зорьдог маш өндөр түвшинг илэрхийлж буй юм. Хоёр гараа бүхэлд нь шатаах гэдэг хөндлөнгийн хүний нүдээр бол маш хөндүүр зовиуртай мэт харагдах боловч Их бодисадвагийн түвшинд хүрсэн хүний хувьд бол огтхон хөндүүр зовиуртай үйл биш юм. Өөрөөр хэлбэл сургаалыг дэлгэрүүлэхийн төлөө өөрийгөө хэд

бол хэд золиосолсон ч тэрхүү золиос нь огтхон ч тухайн хүний хувьд хэцүү зовиуртай зүйл биш юм. Энэ л “өөрөөсөө хүсэмжлэн сургаал айлдан түгээх” хэмээх түвшин юм. Энэ нь ийм түвшинд хүрэхгүй бол жинхэнэ бодисадва гэж хэлэхэд бэрх гэдгийг айлдсан сургаал юм.


Энэ хэсгийг чимээгүй уншсаны дараа би өөрийн эрхгүй ээждээ хандаж “Та харж л байгаарай хагалгаа заавал амжилттай болох болно” гэж хэлсэн юм. Тэгээд бүх зүйл яг миний хэлсний дагуу болов. Одоо миний эмчилгээ сүүлийн шатанд ороод байгаа билээ.

Өөрт тохиолдсон энэ явлаар дамжуулан одоо хэмээх энэ цаг хугацаанд хамаг чадлаараа амьдрах хэрэгтэй гэдгийг би ойлгосон юм. Үүнээс хойш би Хамаг амьтныг үзэн баясагч бодисадва шиг амьдарна гэж бодож байна. Энэхүү эдгэсэн гараа ашиглан, сургаал хэрэгжүүлж, хүмүүсийг сургаал болон аз жаргалын замд хөтлөх хүн болж, бурханы ачийг хариулах болно.

Бурхан багш, үүсгэн байгуулагч танд баярлалаа. РКК нийгэмлэгийн ерөнхийлөгч танд байрлалаа. Та бүхэнд баярлалаа.



Илтгэл тавьж байгаа байдал



Мэдэхгүй өөрийгөө мэдэх нь

Хүний амьдрал тэр чигээрээ дадлага сургалт байдаг. Тиймээс бид үргэлж сурч боловсорёе гэсэн сэтгэлзүйтэй байх чухал. Суралцахын тулд сэтгэл уян хатан байж, төлөв даруу байхгүй бол болохгүй юм.

Өөрийгөө аягатай зүйрлээд үзье. Би гэдэг аяганд дүүрэн ус байвал дахиад нэмж ус орох зайгүй болно. Өөрийн сурсан мэдлэг ялихгүй зүйл атал хорвоо ертөнцийн бүх зүйлийг мэдчихсэн мэт аашлан, өөрийн ахархан бодолдоо автагдаж бүх зүйл тийм байх ёстой мэт бодох нь дүүрэн устай аяга бусдыг хүлээж авахгүйтэй адил юм.

Хүн гэдэг өөрийнхөөрөө зүтгэж, зөрүүд болохын хирээр өсөж хөгжих нь удаан болдог. Тийм учраас даруу төлөв зан юунаас ч илүү чухал билээ.

Юуны түрүүнд би юу ч мэдэхгүй, юу ч ойлгоогүй хэмээн өөрийгөө таньж мэдэх явдал чухал.

Мэдэхгүй гэдгээ мэдэх, энэ бол сурахыг эрхэмлэгч хүний хамгийн чухал үндсэн зан төлөв мөн.



Инээмсэглэл хэмээх үйлээр дамжуулж дармаг олж харах нь

Column

Сургаалыг ухаарч ойлгох юм бол бүх хүмүүс аз жаргалтай амьдарч чадна. Энэ бол буддагийн амлалт юм. Тэгвэл яавал сургаалыг өөрийн болгож чадах вэ? Энэ бол маш энгийн зүйл бөгөөд бурханы зам мөрөөр замнах явдал билээ.

Инээмсэглэх үйл нь ч гэсэн бурханы үйлийн нэг хэсэг юм. Инээмсэглэл бэлэглэснээр эргэн тойрныг энх тайван болгохоос гадна өөрөө ч гэсэн тайвширч эрч хүчтэй болдог. Үүгээр зогсохгүй инээмсэглэх үйлийг хэрэгжүүлснээр бид дармаг өөрийн болгож чадна.

Инээмсэглэл дүүрэн баяр хөөртэй байвал гэр бүл энх тунх амар тайван болно. Сэтгэл ч дулаахан болно. Яагаад гэвэл юм бүхэн хувирч өөрчлөгддөг хэмээх сургаал үйлчилж байгаа учраас юм. Ямар нэгэн бодол, сэтгэлийн зовлон зэрэгт баригдсан байвал нүүрэнд инээмсэглэл тодрохгүй. Үүнд ч гэсэн жинхэнэ үнэний хууль үйлчилж байгаа юм. Тиймээс элдэв бодлоосоо салж инээмсэглээд үзээрэй. Ингэснээр энх амгалан ертөнц бий болох болно.

Инээмсэглэх үйлээр дамжуулж жинхэнэ үнэний хууль хэрхэн үйлчилдэгийг харж, жинхэнэ үнэний хуулийг ашиглаж чаддаг болцгооё.

Олон Улсын Хэлтсийн дарга
Мизүтани Шооко

Рисшо Косей Кай Олон Улсын Нийгэмлэг (IBC) Цэцгийн баяраа тэмдэглэв

Олон Улсын Нийгэмлэг (IBC) Бурхан багшийн төрсөн өдөр буюу Цэцгийн баяраа 2012 оны 4 сарын 15-нд цэлмэг сайхан өдөр тэмдэглэж өнгөрөөв.

Нийт 386 хүн оролцсоны дотор 23 улсын 169 хүмүүс байв. Энэтхэг, Шриланка улсын элчин сайдын яамнаас зочид төлөөлөгчид оролцов.

Ёслол дээр Японы үндэсний хувцас өмссөн хүүхдүүд жагсаал хийж, улс болгоны төлөөллүүд бурханд идээ будаа өргөж, мөн улс улсын хэл дээр Мөргөлийн Гурван Эрдэнэ сургаалыг уншив. Түүний дараа Ph.D Мириам Рэвэрин сургаал айлдаж, Шагжамүни будда энэ ертөнцөд мэндэлсний утга учрын талаар илтгэл тавьсан юм.

Ёслолын гадаа талбайд Цайны ёслол (Садо), Бийрэн бичлэг (Шодо) зэрэг Японы соёлыг танилцуулах булан нээсэн байв.

Тус олон улсын цэцгийн баяр 11 жилийн өмнө анх зохион байгуулагдсан ба тухайн үед 5


гадаад хүн оролцож байсантай харьцуулбал өдгөө 400 орчим хүмүүс цугладаг болтлоо өргөжөөд байна. Энүү баяр нь цаашид ч улс үндэстэн хамааралгүй олон хүнийг бурхан багшийн сургаалтай учруулах боломж өгөх баяр байгаасай хэмээн хүсэж байна.



Чихэртэй цай (Ама-Ча)-ны өргөл

Рисшо Косей Кай байгууллагын тухай

Рисшо Косей кай нь 1938 онд Үүсгэн байгуулагч Нивано Никкёо бодон Хамтран үндэслэгч Наганүма Мёко нарын санаачлагаар үүсгэн байгуулагдсан. Манай байгууллага нь "Гурван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар"-ын сургаалыг гол номлолоо болгосон эгэл хүмүүс нэгдсэн буддын шашины байгууллага юм. Өөрөөр хэлбэл бурхан багшийн сургаалыг гэр, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлэх замаар дэлхийн энх тайвныг бүтээн байгуулах гэсэн зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикогийн удирдлага дор сургаал түгээх үйлсэд зүтгэж, шашины бусад байгууллага болон дэлхийн олон орны хүмүүстэй гар бариц, энх тайвны олон янзын үйл ажиллагаа явуулж байна.



SHAN-ZAI Volume 80 (May 2012)

Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс

Хаяг: Fumonkan, 2-6-1 Wada Suginami-ku, Tokyo, Japan. PO Box 166-8537 TEL: 03-5341-1124 FAX: 03-5341-1224 E-mail: shanzai@kosei-kai.or.jp

※Энэхүү сэтгүүл нь Япон, Англи, Хятад, Португал, Тай, Монгол хэл дээр тогтмол хэвлэгдэн гарч байна. Зарим дугаар нь бусад орны хэл дээр хэвлэгдэх торнолдол байдаг.

※Санал хүсэлт, сэтгэгдэл байвал дээрх хаягаар холбоо барина уу.

※ Хувийн зорилгоор ашиглах тохиолдолд Олон улсын хэлтэстэй холбоо барина уу.

Rissho Kosei-kai Overseas Dharma Centers

2012

Rissho Kosei-kai International

5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1124 Fax: 81-3-5341-1224

Rissho Kosei-kai International of North America (RKINA)

4255 Campus Drive, University Center A-245 Irvine,
CA 92612, U.S.A.
Tel: 1-949-336-4430 Fax: 1-949-336-4432
e-mail: info@rkina.org <http://www.buddhistcenter-rkina.org>

Branch under RKINA

Rissho Kosei-kai of Tampa Bay
2470 Nursery Rd. Clearwater, FL 33764, USA
Tel: (727) 560-2927
e-mail: rktampabay@yahoo.com
<http://www.rkina.org/tampabay>

Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huankhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 Fax: 66-2-716-8218
e-mail: thairissho@csloxinfo.com

Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.
Tel: 1-808-455-3212 Fax: 1-808-455-4633
e-mail: info@rkhawaii.org <http://www.rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center
1817 Nani Street, Wailuku, Maui, HI 96793, U.S.A.
Tel: 1-808-242-6175 Fax: 1-808-244-4265

Rissho Kosei-kai Kona Dharma Center
73-4592 Mamalahoa Highway, Kailua, Kona, HI 96740, U.S.A.
Tel: 1-808-325-0015 Fax: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Church of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.
Tel: 1-323-269-4741 Fax: 1-323-269-4567
e-mail: rk-la@sbcglobal.net <http://www.rk-la.com>

Rissho Kosei-kai Dharma Center of San Antonio
6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.
Tel: 1-210-561-7991 Fax: 1-210-696-7745
e-mail: dharmasanantonio@gmail.com

Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona

Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado

Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego

Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.
Tel: 1-650-359-6951 Fax: 1-650-359-6437
e-mail: rkksf@sbcglobal.net

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center
28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, U.S.A.
Tel: 1-253-945-0024 Fax: 1-253-945-0261
e-mail: rkseattle@juno.com

Rissho Kosei-kai of Sacramento

Rissho Kosei-kai of San Jose

Rissho Kosei-kai of Vancouver

Lotus Buddhist Circle
851 N. San Mateo Drive, San Mateo, CA 94401, U.S.A.

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, U.S.A.
Tel: 1-212-867-5677 Fax: 1-212-697-6499
e-mail: koseiny@aol.com

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, U.S.A.
Tel & Fax: 1-847-394-0809
e-mail: murakami4838@aol.com

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112, U.S.A.
Tel & Fax: 1-405-943-5030
e-mail: ok.risshokoseikai@gmail.com <http://www.rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

Rissho Kosei-kai Buddhist Center of Klamath Falls
724 Main St., Suite 214, Klamath Falls, OR 97601, U.S.A.
Tel: 1-541-810-8127

Rissho Kosei-kai, Dharma Center of Denver
1571 N Race St., Denver, Colorado 80206, U.S.A.
Tel: 1-303-810-3638

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton
446 "B" Patterson Road, Dayton, OH 45419, U.S.A.

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,
CEP 04116-060, Brasil
Tel: 55-11-5549-4446 Fax: 55-11-5549-4304
e-mail: rissho@terra.com.br <http://www.rkk.org.br>

Rissho Kosei-kai de Mogi das Cruzes
Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,
CEP 08730-000, Brasil
Tel: 55-11-4724-8862

Rissho Kosei-kai of Taipei

4F, No. 10 Hengyang Road, Zhongjheng District, Taipei City 100
Tel: 886-2-2381-1632 Fax: 886-2-2331-3433

Rissho Kosei-kai of Taichung

No. 19, Lane 260, Dongying 15th St., East Dist.,
Taichung City 401
Tel: 886-4-2215-4832/886-4-2215-4937 Fax: 886-4-2215-0647

Rissho Kosei-kai of Jilong

Rissho Kosei-kai of Tainan

No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701
Tel: 886-6-289-1478 Fax: 886-6-289-1488

Rissho Kosei-kai of Pingtung

No. 4, Lane 60, Minquan Road, Pingtung City,
Pingtung County 900
Tel: 886-8-732-1241 Fax: 886-8-733-8037

Korean Rissho Kosei-kai

423, Han-nam-dong, Young-San-ku, Seoul, Republic of Korea
Tel: 82-2-796-5571 Fax: 82-2-796-1696
e-mail: krkk1125@hotmail.com

Korean Rissho Kosei-kai of Pusan

1258-13, Dae-Hyun-2-dong, Nam-ku, Kwang-yok-shi, Pusan,
Republic of Korea
Tel: 82-51-643-5571 Fax: 82-51-643-5572

Korean Rissho Kosei-kai of Masan

Branches under the Headquarters

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point,
Hong Kong, Special Administrative Region of the People's Republic
of China
Tel: 852-2-369-1836 Fax: 852-2-368-3730

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

39A Apartment, room number 13, Olympic street, Khanuul district,
Ulaanbaatar, Mongolia
Tel & Fax: 976-11-318667
e-mail: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Sukhbaatar

18 Toot, 6 Orts, 7 Bair, 7 Khoroo, Sukhbaatar district, Ulaanbaatar, Mongolia

Rissho Kosei-kai of Sakhalin

1-72 Amyrskaya Street, Yuzhno-Sakhalinsk
693000, Russian Federation
Tel & Fax: 7-4242-43-78-56

Rissho Kosei-kai (Geneva)

1-5 route des Morillons P.O Box 2100 CH-1211 Geneva 2 Switzerland
Tel: 41-22-791-6261 *Fax:* 41-22-710-2053
e-mail: rkkgva@wcc-coe.org

Rissho Kosei-kai of the UK**Rissho Kosei-kai of Venezia**

Castello-2229 30122-Venezia Ve Italy
Tel: Contact to Rissho Kosei-kai (Geneva)

Rissho Kosei-kai of Paris

86 AV Jean Jaures 93500 Tentin Paris, France
Tel: Contact to Rissho Kosei-kai (Geneva)

Rissho Kosei-kai of Sydney**International Buddhist Congregation (IBC)**

5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1230 *Fax:* 81-3-5341-1224
e-mail: ibcrk@kosei-kai.or.jp <http://www.ibc-rk.org/>

Rissho Kosei-kai of South Asia Division

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
Tel & Fax: 880-31-2850238

Thai Rissho Friendship Foundation

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218
e-mail: info.thairissho@gmail.com

Rissho Kosei-kai of Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
Tel & Fax: 880-31-2850238

Rissho Kosei-kai of Dhaka

House No.465, Road No-8, D.O.H.S Baridhera,
Dahka Cand.-1206, Bangladesh
Tel: 880-2-8316887

Rissho Kosei-kai of Mayani

Mayani Barua Paya, Mirsarai, Chittagong,
Bangladesh

Rissho Kosei-kai of Patiya

Patiya, Post office road, Patiya, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Domdama

Domdama, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Cox's Bazar

Phertali Barua Para, Cox's Bazar, Bangladesh

Rissho Kosei-kai of Satbaria

Satbaria, Hajirpara, Chandanish, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Laksham

Dupchar (West Para), Bhora Jatgat pur, Laksham, Comilla,
Bangladesh

Rissho Kosei-kai of Raozan

West Raozan, Ramjan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Chendirpuni

Chendirpuni, Adhunagor, Lohagara, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Sri Lanka

382/17, N.A.S. Silva Mawatha, Pepiliyana, Boralesgamuwa, Sri Lanka
Tel: 94-11-2826367 *Fax:* 94-11-4205632

Rissho Kosei-kai of Polonnaruwa

No. 29 Menik Place, Kaduruwela, Polonnaruwa,
Sri Lanka

Rissho Kosei-kai of Habarana

151, Damulla Road, Habarana, Sri Lanka

Rissho Kosei-kai of Galle

No.43 Melban Park Akmeemana, Galle, Sri Lanka

Rissho Kosei-kai of Kandy-wattegama

12 Station Road, Kapugastota, Sri Lanka

Branches under the South Asia Division**Delhi Dharma Center**

B-117 (Basement Floors), Kalkaji,
New Delhi-110019, India
Tel: 91-11-2623-5060 *Fax:* 91-11-2685-5713
e-mail: sakusena@hotmail.com

Rissho Kosei-kai of West Delhi

A-139 Ganesh Nagar, Tilak Nagar
New Delhi-110018, India

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar,
KOLKATA 700094, India

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur,
Kathmandu, Nepal
Tel: 977-1-552-9464 *Fax:* 977-1-553-9832
e-mail: nrkk@wlink.com.np

Rissho Kosei-kai of Lumbini

Shantiban, Lumbini, Nepal

Rissho Kosei-kai of Singapore**Other Groups****Rissho Kosei-kai Friends in Shanghai**

1F, ZHUQIZHAN Art Museum, No. 580 OuYang Road,
Shanghai 200081 China